



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 477

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан дөрөв аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан нэг иргэний дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн Н.Алтанзаяад үүрэг болгосугай.

5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА




E:\NAJG\Alban blanknii hevlelt\Tushaal\A\15.07.31 DAJHM.docx

УОА0453

0 115050024

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 07 сарын 31
өдрийн 177 тоот тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2015.07.30

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Номадс резидэнс ХХК	Эйч-9	Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Амарын гудамж 2

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 07 сарын 31
өдрийн 177 тоот тушаалын хоёрдугаар
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ


2015.07.30

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	ЭБЗ ХХК	Амарбаясгалант	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 15А/5
2	Текко ХХК	Хаан	Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, 7-р хороолол Их тойруу 22
3	Алтан наран трейд ХХК	247	Баянгол дүүрэг, 12-р хороо, Хасбаатарын гудамж 3Б
4	Алтан наран трейд ХХК	Эрхэс	Баянгол дүүрэг, 12-р хороо, Хасбаатарын гудамж 3А

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2015 оны 07 сарын 31
едрийн 1977 тоот тушаалын гуравдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ

2015.07.30

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Л.Бурмаа	Мини	Баянгол дүүрэг, 14-р хороо, Хасбаатарын 18/1

-ooOoo-